

**ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга		
Хуралдааны товч тэмдэглэл:		1-2
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:		3-7

1.Дэд хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл

3-7

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Хүний эрхийн дэд хорооны
4 дүгээр сарын 13-ны өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хүний эрхийн дэд хорооны дарга С.Эрдэнэболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 48 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: О.Номинчимэг, Л.Соронзонболд;

Тасалсан: Ж.Баярмаа, П.Сайнзориг, Х.Тэмүүжин.

Дэд хорооны дарга С.Эрдэнэболд хэлэлцэх асуудлын 2 дугаарт орсон Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүй, эд хөрөнгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, нөхөн төлбөр олгох талаар судалж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хохирол барагдуулах үйл ажиллагааны тухай хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн явцын талаарх мэдээлэл сонсох асуудлыг хойшлуулж, Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар сонсох нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

С.Эрдэнэболд: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 1
Бүгд: 6
83.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Дэд хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Дэд хорооны дарга С.Эрдэнэболд Хүний эрхийн дэд хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг танилцуулав.

Төлөвлөгөөний төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нарагийн тавьсан асуултад Дэд хорооны дарга С.Эрдэнэболд хариулж, тайлбар хийв.

С.Эрдэнэболд: Хүний эрхийн дэд хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 1
Бүгд: 6
83.3 хувийн саналаар батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 15 минут үргэлжилж, 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр 15 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД
ХОРООНЫ ДАРГА

С.ЭРДЭНЭБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
14 цаг 48 минут.

ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Эрдэнэболд: Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны 2026 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна. Дэд хорооны гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар Эрдэнэболд, Оюунсайханы Алтангэрэл, Хүрэлбаатарын Баасанжаргал, Баярмагнайн Баярбаатар, Мөнхтөрийн Нарантуяа-Нара, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн нарын ирцтэйгээр 54,5 хувийн ирцтэйгээр дэд хорооны хуралдаан эхэлж байна.

Өнөөдрийн хэлэлцэх асуудалд та бүхэнд урьдчилж 2 мэдээллийг хүргүүлсэн байгаа. 1 дүгээрт, Дэд хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл. 2 дугаарт, Ажлын хэсгийн үйл ажиллагааны явцын талаарх мэдээлэл. Ажлын хэсэг нь болохлоор эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогч, хамгаалалт, туслалцаа үзүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх нь харьцуулсан судалгааны зөвлөмж сонсох ёстой байсан. Тэгээд би одоо горимын санал гаргаад энэ асуудлыг хэлэлцэх асуудлаас өнөөдрийн хуралдаанаар хасаад, дараа долоо хоногт болгохоор болж байгаа. Учир нь болохлоор яг энэ ажлын хэсэг өнгөрсөн долоо хоногт хуралдсан. Тэгээд эрүү шүүлтийн улмаас хохирсон гэх хүмүүсийн хэрэг дээр дүн шинжилгээ хийх, энэ хаалттай хуралдаан болсон байгаа. Хэсэгчилсэн хаалттай хуралдаан болсон байгаа. Учир нь бол нууцтай холбоотой хэргүүд байсан. Тэгээд энэ асуудлыг Хууль зүйн байнгын хорооны дарга Дамдины Цогтбаатар даргад уламжлаад, дараагийн хурал дээр ХЗБХ-ны хуралд танилцуулахаар болсон байгаа. Тийм учраас Дэд хорооны хуралд биш, том Байнгын хорооныхоо хуралд танилцуулах болсон учраас энэхүү горимын саналыг гаргаж байна. Горимын саналаар санал хураалт явуулах уу?

Тус хэлэлцэх асуудлыг Дэд хорооны хурлаас ХЗБХ-ны хурал руу шилжүүлэх, шилжүүлэн танилцуулж хэлэлцүүлэхийг горимын саналыг нь, горимын саналаар санал хураах. Тэгээд дэмжиж байгаа гишүүд, санал хураалтад бэлдэх гэж байдаг билүү? Тийм, санал хураалтад бэлдчихье. Саяын хэлсэн томъёоллоор өөрөөр хэлбэл хэлэлцэх асуудлын 2-т байгаа Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчдын асуудалтай холбоотойгоор Дэд хорооны хэлэлцэх асуудлыг Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцүүлэхийг дэмжиж байгаа гишүүд саналаа өгнө үү. Санал хураалт. 83,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд үндсэн хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудалдаа орохоос өмнө өнгөрсөн 2025 оны 12 дугаар сард ХЗБХ-ны дэргэдэх Хүний эрхийн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, бүгдээрээ хүлээж авсан байгаа. Ингээд 2026 оны Дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг та бүхэндээ урьдчилж тарааж өгсөн байгаа. Монгол Улсын Их Хурал өөрөө нээлттэй, иргэдэд

мэдээллээ ил тод илэрхийлдэг байх энэ журмын дагуу энэхүү зорилтыг та бүхэнд уншиж танилцуулна. Араас нь болохоор Их Хурлын гишүүдээс асуулт, үгтэй холбоотой дэгийн дагуу одоо хэсгийг явуулна.

Зорилтын 1 дүгээрт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 407 дугаар ангид, 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн үйл ажиллагаатай танилцах, хүний эрх, эрх чөлөөг хангаж ажиллаж байгаа эсэх талаар санал, дүгнэлт гаргах. Үүнтэй холбогдуулан Дэд хорооны гишүүдийн албан томилолт газар дээрх хяналт шалгалт зохион байгуулах. Мөн гишүүн хоригдол, албан хаагчидтай шууд уулзах сонсгол хийх. Үр дүнд нь Дэд хорооны дүгнэлт, зөвлөмж баталж, Хууль зүй, дотоод хэргийн яам болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт хүргүүлэх. Илэрсэн асуудлаар шаардлагатай бол парламентын хяналтын сонсгол зохион байгуулах. Энэ ажил бол 4 дүгээр сарын 2 дахь долоо хоногт зохион байгуулна гэж үзэж байгаа.

2 дугаарт бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын үйл ажиллагаатай танилцах, хүүхдийн эрх, эрх чөлөөг хангаж ажиллаж байгаа эсэх талаар санал, дүгнэлт гаргах. Ингэхдээ гишүүдийн оролцоотой тусгайлан хяналт шалгалт хүүхдийн эрхийн асуудлаар нээлттэй болон хаалттай сонсгол хийх. Хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй гэж үзвэл хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах ийм төлөвлөгөө байгаа. Алтангэрэл гишүүн яасан билээ?

3 дугаарт, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйл ажиллагаатай танилцах. Энэ хүрээнд Дэд хорооны гишүүдийн хяналтын ажил, сэтгэцийн эрүүл мэндийн салбарын асуудлаарх салбарын сайд, холбогдох байгууллагыг оролцуулсан сонсгол хийх, үр дүнд нь бодлогын зөвлөмж, шаардлага хүргүүлэх ажил байгаа. Би та бүхэнд тараагдсан учраас ард талын үр дүн гээд нарийвчилсан зүйлүүдийг уншихгүй байгаа шүү.

4 дүгээрт, 2027 оны улсын төсвийн төслийн хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хүрээнд орон нутгийн төсвийн тодорхойлолт, зарцуулалт, хүний эрхийн хамгаалалт болон хэрэгжилтэд хэрхэн нөлөөлөхийг үнэлж, хүний эрхийн шалгуураар үзүүлэлтийг тусган шинжилгээ, зөвлөмж боловсруулах.

5 дугаарт нь, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Их Хурлын 24-өөс 28 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд 2026 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Улсын Их Хурлын үйл ажиллагааг Хүн төвтэй, хүний эрхийг дээдэлсэн байдлаар зохион байгуулж, иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийн чанарыг сайжруулах талаарх саналыг хүргүүлэх энэ ажлууд байна.

6 дугаарт нь, улсын нэгдсэн төсөв, улсын төсөвт хүний эрхийг хэрхэн хангаж байгаа талаар шалгуур үзүүлэлт, дүн шинжилгээ хийх сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулах. Энэ аягүй чухал хэсэг байгаа.

7 дугаарт нь, Улсын Их Хурлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах үйл ажиллагаанд иргэний оролцоог хангах талаар тогтоолын төслийг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, батлуулах ийм зүйлийг төлөвлөсөн байгаа.

8 дугаарт нь болбол Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газраар Улсын Их Хурлын баталсан тогтоолын биелэлтэд дүн шинжилгээ хийлгэх.

9 дүгээрт нь, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлгээс ирүүлсэн дүгнэлт, зөвлөмж, үүнд үндэслэсэн цаашид авах арга хэмжээний мэдээллийг нэгтгэх, салбар дундын хэлэлцүүлэг зохион байгуулах.

10 дугаарт, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцыг хэрэгжүүлэх ажлыг аймаг, дүүргийн Засаг дарга нартай байгуулах гэрээнд заавал тусгадаг байх чиглэлийг Засгийн газарт хүргүүлэх.

11 дүгээрт нь, Хүний эрхийг хангах үндэсний 2 дугаар хөтөлбөр боловсруулах хүрээнд Монгол Улс дахь хүний эрхийн нөхцөл байдлын дүн шинжилгээг боловсруулах талаар Олон улсын парламентын холбоотой санал солилцох уулзалт хийх.

12 дугаарт, хүний эрх, жендерийн асуудлаарх өөрийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилттэй холбоотой асуудлаар Олон улсын парламентын холбоотой санал солилцох уулзалт хийх. Энэ Номинчимэг гишүүнээс ирүүлсэн саналууд байна.

13 дугаарт, парламентын өөрийн үнэлгээний хүрээнд гарсан санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Хүний эрхийн дэд хорооны 2024 оны 1 дүгээр тогтоолын хэрэгжилттэй Дэд хорооны хурлаар танилцах.

14 дэх нь хүний үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийн хэрэгжилт, цахим орчин дахь хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар дүгнэлт гаргах.

15 дугаарт, Хүүхдийн эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлаар холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай уулзалт зохион байгуулах. Энэ хийгдээд явж байгаа.

16 дугаарт, Хүүхэд хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлаар холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай уулзалт зохион байгуулах.

17-д нь, Хүний эрхийн дэд хорооны гишүүдийн Хүний эрхийн форум байгууллагын төлөөлөлтэй хамтын ажиллагааг тодорхойлох гэсэн байгаа. Товчхондоо бол ингээд тоймыг нь та бүхэнд уншиж үзүүллээ.

2025 оны тухайд бол сар болгоны 2 дахь долоо хоногийн лхагва гаргийн өглөөний 10 цагаас бид Хүний эрхийн форумтай уулзсан. Тэгэхээр Хүний эрхийн дэд хорооны нийт гишүүддээ өнгөрсөн жил 19 ажил төлөвлөгдсөнөөс 17 нь бол амжилттай хэрэгжсэн гээд бид 12 сард дүгнэсэн. 2 ажил дээр бол одоо яг энэ хуулийн төслүүдтэй холбоотой ялангуяа Алтангэрэл гишүүнийг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ажиллаж байхад бид энэ Хүний эрхийн багц хуультай холбоотой асуудлууд байсан. Энэ бол ингээд дахиад одоо Засгийн газар солигдсонтой холбогдуулаад тэрнээс чинь хойш ингээд 2 Засгийн газар, 2 Хууль зүй, дотоод хэргийн сайд таны араас гарч ирсэн байгаа шүү дээ. Тэгэхээр энэ ажлууд одоо залгагдаад хийгдээд явах байх гэж үзэж байгаа.

Тэгээд Хүний эрхийн дэд хорооны шинэ дарга ирэх долоо хоногт тодорно. Энэ тодорсны дараагаар яг энэ дараагийн энэ уулзалтуудаа шинэ манлайлал нь аваад, хэрэгжүүлээд явах байх гэж бодож байгаа. Ингээд бид олон нийтэд хандаад Хүний эрхийн дэд хороо гэсэн цахим сүлжээг ажиллуулсан, тайлангуудыг ингээд тогтмол өгөөд явсан байгаа.

2026 оны төлөвлөгөөг бид боловсруулахдаа Хүний эрхийн дэд хорооны гишүүн Улсын Их Хурлын гишүүд болон бусад Хүний эрхийн Үндэсний Комисс, бусад байгууллагууд болон бусад субъектүүдээс энэ санал, зөвлөмжийг авсан. Их Хурлын бүтцийн байгууллагуудаасаа ч гэсэн санал, зөвлөмж авсны дагуу дээрх төлөвлөгөөний төслийг та бүхэндээ танилцуулж байна.

Ташрамд дурдахад энэ урьд нь Ё.Отгонбаяр гишүүн асан Хүний эрхийн дэд хороог ахалж байхдаа яг энэ төлөвлөгөө батлуулдаг, тайланг тавьдаг ийм соёлтой байсан. Бусад Хүний эрхийн дэд хорооны зүгээс бол одоогийн байдлаар архивд ийм бүртгэгдсэн тайлан юм уу, төлөвлөгөөний зүйл бол тусгагдсан бидэнд олдоогүй байна. Тийм учраас Хүний эрхийн дэд хороо бол нэг талаас хариуцлагатай ажиллахын тулд, 2 дугаарт энэ төрийн ой санамж ил тод байх үүднээс энэ тайланг болон энэ тодорхой зорилтуудыг дэвшүүлж байгаа. Тэгээд энэ бол яг одоо Хүний эрхийн дэд хороон дээр заавал ийм хөтөлбөр батлуулна гэсэн зүйл бол байхгүй.

Гэхдээ миний бие 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Хүний эрхийн дэд хорооны дарга болохдоо жил болгон тогтмол энэ тайлангаа тавьж, зорилт, хөтөлбөрүүдээ дэвшүүлж байна гэсэн байр сууриа илэрхийлсний дагуу энэ хөтөлбөрийг та бүхэндээ санал болгож байгаа юм. Дэд хорооны даргын зүгээс 2026 оны хөтөлбөрийн төсөөллийг та бүхэндээ танилцууллаа. Асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн Дэд хорооны гишүүн байвал нэрээ өгнө үү? Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүнээр тасалъя. Асуултаа асууя.

М.Нарантуяа-Нара: Дэд хорооныхоо гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд 26 оны үйл ажиллагааны төлөвлөгөө бол нэлээн боловсронгуй, маш дэлгэрэнгүй, яг ингээд бүгдээрээ сайхан хэрэгжвэл маш үр дүнтэй ажил болохоор харагдаж байна. Тэгээд энэ дунд миний бас нэг, надад ирсэн гомдлын дагуу энэ Шүүхийн ерөнхий зөвлөлийн, Шүүхийн ерөнхий зөвлөл дэх ажлын байрны бэлгийн дарамттай холбоотой иргэн Чулуунбатын Ханддулам гэдэг хүний асуудал надад ирсэн. Тэгээд, би сая бид түрүүн микрофонгүй үед ярилцлаа л даа. Тэгээд энэ хүний асуудлаар бид энэ чинь манай хороо чинь шууд хууль зүйн дэд хороондоо, Хууль зүйн байнгын хороондоо харьяалагдаж байгаа. Эндээсээ бид одоо сонгоод, томилоод, батлаад, томилоод явуулдаг Шүүхийн ерөнхий зөвлөлд ийм ажлын байрны бэлгийн дарамттай холбоотой асуудал гарсныг бид яг одоо энэ шүүхийн хугацаа явж байгаа үед нь ч юм уу, эсхүл одоо явагдаж байгаа процессынх нь үед нь энэ асуудлыг хэлэлцэх ямар нэгэн тийм боломж, юм хум байдаг уу? Хэрвээ тэгчихвэл бид ямар нэгэн байдлаар авч хэлэлцээд, энийг асуудал болгоод хурлаар оруулж ирээд явчихвал энэ шүүхэд хөндлөнгөөс нөлөөлөх гэсэн оролдлого энэ тэр болох гэсэн тийм юмнууд байна уу? Тэр талаар бас нэг асуучихъя.

С.Эрдэнэболд: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн бол энэ Хүний эрхийн дэд хорооны ажилд маш идэвхтэй оролцдог. Маш олон асуудлууд дээр өөрт нь маш олон хүмүүс ханддаг. Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хороон дээр бол маш олон асуудлууд ирдэг. Эдгээрийг бид яг одоо байгаа хууль тогтоомжийнхоо хүрээнд харьяаллын дагуу шилжүүлдэг. Араас нь гомдол, санал дахиад гарвал энэ асуудал ямар шатандаа, яаж явж байгаа талаар лавлагаа авдаг. Яг одоо саяын

ярьсан асуудал маань Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүний хэлж байгаа асуудал маань шүүхийн шатад явж байгаа асуудал учраас бид шүүхийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй, хараат бус, бие даасан байдлыг нь хангах хүрээнд одоо гомдлыг Хүний эрхийн Үндэсний Комисс руу л уламжилснаас биш ямар нэгэн байдлаар Шүүхийн ерөнхий зөвлөл рүү гэх юм уу, Дээд шүүх рүү энэ талаар хандах эрх зүйн орчин бол боломжгүй байгаа гэдгийг тайлбарламаар байна.

Ер нь бол маш олон асуудлууд ирснийг бид шилжүүлсэн. Энэ статистик тоон мэдээг 12 дугаар сард бид 23-ны өдөр тайлангаа тавихдаа бол хэчнээн хэмжээнд өргөдөл, гомдол ирээд, хэдийг нь яаж шийдсэн, хэчнээн нь жишээлбэл ямар байгууллагатай, ямар субъекттэй холбоотой байсан бэ гэдгийг тайлангаа тавиад та бүхэнд танилцуулсан байгаа. Яг зарим нэгэн онцгой тохиолдлууд тухайлбал 2024 оны 8 дугаар сард гарсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт хоригдож байхдаа амь насаа алдсан хэрэг дээр манайх хуралдаад, түүн дээр сонсголын асуудал хийсэн. Мөн эрүүдэн шүүхтэй холбоотой асуудлын улмаас бид бас Дэд хорооноос, Хууль зүйн байнгын хорооноос ажлын хэсэг гаргаад ажиллаад ингээд явж байгаа. Ирэх долоо хоногт Хууль зүйн байнгын хороогоор энүүгээр танилцуулга нь явагдана.

Ингээд Дэд хороотой холбоотой ажлын хэсгүүд юм уу, тодорхой сонсголууд, болсон асуудлын үр дүнг бол тухай бүрд нь танилцуулаад явж байгаа. Хэрвээ яг энэ асуудлыг бас энэ чинь нөгөө хүний, хувь хүний нууцтай холбоотой эд нар асуудлыг бид дандаа хаалттай байдлаар ярилцаад явсан байгаа. Яг энэ тохиолдол бол бид шүүхийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх боломжгүй гэдэг шалтгаанаар тэр процессынхоо дагуу шилжүүлээд явж байгааг хэлмээр байна. Тодруулах уу? Их Хурлын гишүүдийн зүгээс хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой саналаа хэлэх гишүүн байвал? Байхгүй байна.

2026 оны Хүний эрхийн дэд хорооноос хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг бид 2026 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн энэ төлөвлөгөөт хурлаараа хэлэлцэж дууслаа. Одоогоор 15 цаг 01 минут болж байна. Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны 2026 оны 4 дүгээр сарын 13-ны өдрөөр хэлэлцэгдсэн 26 оны төлөвлөгөөг батлахыг дэмжиж байгаа гишүүд маань дараах саналын томъёоллоор саналаа хураана. Санал хураалтад бэлдье.

26 оны Хүний эрхийн дэд хорооны үйл ажиллагааг дээр танилцуулсан төлөвлөгөөний дагуу батлахыг дэмжиж байгаа Монгол Улсын Их Хурлын гишүүд та бүхэн саналаа өгнө үү. Санал хураалт. 83,3 хувийн саналаар дэмжигдлээ. Монгол Улсын Их Хурлын дэд хороо, Хүний эрхийн дэд хорооны 2026 оны ажил батлагдсантай холбогдуулж, энэ батлагдсан хөтөлбөрийн дагуу ажлаа зохион байгуулж ажиллахыг Хууль зүйн байнгын хорооны ахлах зөвлөх болон ажилтнуудад даалгая.

15.02 цаг

Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан учраас хурлаа хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА